

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгасан зорилтыг хэрэгжүүлэх, практикт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ НЭМЭГДҮҮЛСЭН ТУХАЙД:

Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдэж, хүүхэд хамгааллын төрийн бодлого тодорхойлогдож, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа эрчимжиж байгаа хэдий ч хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг буурахгүй байна.

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд, Монгол Улс дахь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн нийт гэмт хэргийн бүтцэд эзлэх хувийн жин өсөх, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг нэмэгдэх хандлагатай байна.¹

Иймд арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, бэлгийн мөлжлөг гэмт хэргийн улмаас ураг зулбасан, арван зургаан насанд хүрсэн арван найман насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгох, хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 12 жил байсныг 30 жил болгон уртасгахаар төсөлд тусгасан.

Энэ төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгаж, тусгайлан зохицуулснаар хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хүүхдийн эсрэг хүчирхийллийн ноцтой гэмт хэргүүд болох хүчиндэх, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, ял завшуулах явдлаас сэргийлэх ач холбогдолтой гэж үзсэн болно.

ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАЖ, ХЯНАЛТ ТОГТООХ ЖУРМЫН ТУХАЙД:

Бага насны хүүхдийг алах, хүчиндэх, бэлгийн мөлжлөг гэмт хэрэг үйлдэж, шүүхээс оногдуулсан хорих ялыг биечлэн эдэлж буй ялтан зан байдлын хувьд засарч хүмүүжээгүй байхад хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж, хяналт тогтоосон, шүүхийн

¹ “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. 2020. 191 дэх тал

шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, өршөөгдсөн үед цагдаагийн байгууллага хяналт сул тавьсан нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болсон тохиолдол цөөнгүй байна.²

Шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийж үзэхэд, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж суллагдсан, хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллагдаж, хяналтад байх хугацаандаа давтан гэмт хэрэг үйлдэх явдал цөөнгүй байна. Тухайлбал, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн 16 орчим хувийг урьд нь ял шийтгэгдэж байсан хүн үйлдсэн байна.

Иймд хүнийг алах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн /2, 3 дахь хэсэг/-д заасан гэмт хэрэг, арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, бага насны хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг, хоёр, түүнээс олон хүнийг, Монгол Улсын хил нэвтрүүлж, байнга тогтвортой, зохион байгуулалттай гэмт бүлэг хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоохгүй байхаар хуулийн төсөлд тусгасан.

Монгол Улсад авлигатай тэмцэх эрх зүйн орчин зохих түвшинд бүрдсэн хэдий ч Авлигын индексийн үзүүлэлт 2016 оноос тогтмол, огцом буурч байгаа нь авлигатай тэмцэх тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай болохыг харуулж байна. Тухайлбал, Монгол Улс авлигын индексийн дүнгээр 2015 онд 39 оноо авч 72 дугаар байр, 2016 онд 38 оноо авч 87 дугаар байр, 2017 онд 36 оноо авч 103 дугаар байр, 2018 онд 37 оноо авч 93 дугаар байр, 2019 онд 35 оноо авч 106 дугаар байр, 2020 онд 35 оноо авч 111 дүгээр байр, 2021 онд 35 оноо авч 110 дугаар байр, 2022 онд 33 оноо авч 116 дугаар байрт эрэмблэгдсэн үзүүлэлттэй байна.

Монгол Улс дахь авлигын гэмт хэргийн нөхцөл байдал, авлигын хор уршиг, авлигын индексийн үзүүлэлт тогтмол буурсан зэрэг байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэрэгт ял шийтгэгдсэн ялтанг хорих ялаас хугацаанаас нь өмнө суллаж, хяналт тогтоохгүй байх зохицуулалтыг хуульчилж, авлигатай тэмцэх төрийн бодлогыг чангатгасан.

Харин энэрэнгүй ёсны зарчим, хүүхдийн гэмт явдлын онцлогийг харгалзан хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоохгүй байх хязгаарлалтад гэмт хэрэг үйлдэх үедээ арван найман насанд хүрээгүй хүнд хамаарахгүй байхаар тусгасан.

ӨРШӨӨЛ, УУЧЛАЛ ҮЗҮҮЛЭХГҮЙ БАЙХ ТУХАЙД

Өршөөл үзүүлэх тухай хуулиар суллагдсан этгээд бага насны хүүхэд, хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийг үйлдсэн тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, 2006 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2-т зааснаар 3 сар, 1 хоногийн баривчлах ялаар, мөн хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д зааснаар 4 жил, 6 сарын хорих ялаар шийтгүүлж, 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4.4-д зааснаар эдлээгүй үлдсэн 4 жил, 9 хоногийн хорих ялаас өршөөн суллагдсан этгээд болох Т нь 2009 оны 8 дугаар сарын 26-27-нд шилжих шөнө Булган аймгийн Тэшиг сумын ... дугаар багийн нутаг ... гэх газар 13 настай М-ийг биеэ

² “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. 2020. 74 дэх тал

хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан заазуур болон гараараа зодож, толгой, нүүр, гар, хөлд нь олон тооны шарх, цус хуралт үүсгэж, онц харгис хэрцгий аргаар өвтгөн шаналгаж, зовоон тарчлааж хүчиндсэн, хүчиндэх гэмт хэргээ нуун далдлах зорилгоор хохирогчийг нуурын усанд живүүлж алсан³ байна.

Эндээс үзэхэд, гэмт хэрэг үйлдсэн хүнд өршөөл, уучлал үзүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх, үндэслэл, шаардлагыг өндөрсгөх, зарим төрлийн ялангуяа, бага насны хүүхдийг алах, хүчиндэх, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийг өршөөл, уучлалд хамааруулахгүй байхаар хязгаарлалт хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Иймд хүнийг алах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн /2, 3 дахь хэсэг/-д заасан гэмт хэрэг, арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, бага насны хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг, хоёр, түүнээс олон хүнийг, Монгол Улсын хил нэвтрүүлж, байнга тогтвортой, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байхаар хуулийн төсөлд тусгасан.

Харин уучлал үзүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах учраас уучлал үзүүлэх эрхэд хязгаарлалт тогтоохоос татгалзсан болно.

Энэрэнгүй ёсны зарчим, хүүхдийн гэмт явдлын онцлогийг харгалзан өршөөл үзүүлэхгүй байх хязгаарлалтад гэмт хэрэг үйлдэх үедээ арван найман насанд хүрээгүй хүнд хамаарахгүй байхаар хуулийн төсөлд тусгасан.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЯЛЫН БОДЛОГЫГ ЧАНГАТГАСАН ТУХАЙД:

Хүнийг алах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх боломжгүй буюу хүний амьд явах эрх зөрчигддөг тул нийгмийн хор аюулаар ихтэй гэмт хэрэгт тооцогддог.

Сүүлийн 4 жилд хүнийг алах гэмт хэргийн халдлагад 782 хүн өртөж, хохирогчдын 92 хувь нь нас барсан байна. Хүнийг алах гэмт хэрэг, энэ гэмт хэргийн хохирогчдын тоо сүүлийн 3 жил тогтвортой өсөж, хохирогчдын дийлэнх энэ гэмт хэргийн улмаас нас барж, эрүүл мэндэд нь хүнд хохирол учирчээ.

Хүнийг алах гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал, 2019 онд 197 гэмт хэрэгт 4 хүүхэд, 2020 онд 192 гэмт хэрэгт 8 хүүхэд, 2021 онд 194 гэмт хэрэгт 2 хүүхэд, 2022 онд 199 гэмт хэрэгт 7 хүүхэд тус тус хохирсон байна. Үүнээс 2019 онд 4, 2020 онд 8, 2021 онд , 2022 онд 7 бага насны хүүхэд хохирч, нас баржээ.

Хүчиндэх гэмт хэрэг нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдаж, улмаар хүний амьд явах эрх, эрүүл мэндийн халдашгүй байдалд ихээхэн хохирол, хор уршиг учруулдаг нийгэмд хор аюулаар их гэмт хэрэг юм.

³ Булган аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2010 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 84 дүгээр шийтгэх тогтоол

2022 онд хүчиндэх гэмт хэргийн улмаас 552 хүн хохирч, 59 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс хохирсон хүн 94 буюу 20.5 хувиар, гэмтсэн хүн 8 буюу 15.7 хувиар тус тус өссөн байна.⁴

Сүүлийн 4 жилд хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэргийн улмаас 1975 хүн хохирчээ. Ялангуяа, хохирогчдын тоо сүүлийн 3 жилд огцом өссөн байна. Үүний дотор энэ төрлийн гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал, 2019 онд 481 гэмт хэрэгт 169, 2020 онд 505 гэмт хэрэгт 248, 2021 онд 439 гэмт хэрэгт 278, 2022 онд 550 гэмт хэрэгт 362 хүүхэд тус тус хохирчээ.

Гэмт этгээдүүд ихэвчлэн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай бага насны хүүхдийг биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлыг далимдуулан хүч хэрэглэхээр заналхийлэх үйлдлийн аргаар хүчиндсэн байна. Ихэвчлэн эцэг, эхдээ болон бусдад хэлбэл ална, эрүүл мэндэд нь хохирол учруулна хэмээн заналхийлж, бага насны хүүхдийг хүчиндсэн байх бөгөөд хохирогч айж эмээсний улмаас гэмт этгээдийн үйлдлийг нууж өнгөрдөг нь дахин хүчиндүүлэх, цаашид удаан хугацаанд энэ гэмт хэргийн халдлагад өртөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Бага насны хүүхдийг хүчиндэж, улмаар жирэмсэн болгосон, бэлгийн замын халдварт өвчин халдаасан, хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн тохиолдол цөөнгүй хувийг эзэлж байна. Тухайлбал, судалсан эрүүгийн хэргийн дийлэнх хувийг хохирогч хүчиндүүлсний улмаас жирэмсэн болсноор гэмт хэрэг илэрсэн байх бөгөөд хэрэв хохирогч жирэмсэн болоогүй бол тухайн гэмт хэрэг илрэхгүй байх магадлал өндөртэй байна.

Нийгмийн хор аюулаар их, хохирогч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүйд нөхөж баршгүй хохирол, хор уршиг учруулж, насан туршид нь арилшгүй “толбо” үлдээдэг бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах хугацаатай хорих ялын дээд хэмжээ 20 байсныг 25 болгон нэмэгдүүлж, ялын бодлогыг чангаруулахаар хуулийн төсөлд тусгасан.

Хугацаатай хорих ялын дээд хэмжээг дээр дурдсан 2 гэмт хэрэгт 5 жилээр нэмэгдүүлж, 25 жил болгосонтой холбоотойгоор одоо бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн 25 жил хоригдсоны дараа шүүх хуульд заасан нөхцөл, шаардлагыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэхээр заасан байгааг 30 жил болгон нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЖОЛООДОХ ЭРХИЙГ БҮХ НАСААР ХАСАХ ТУХАЙД:

Улсын хэмжээнд 2023 оны эхний 8 сарын байдлаар 15094 зам тээврийн осол, хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өсөж, нийт ослын 12569 буюу 83.2 хувь нийслэлд, 2525 буюу 16.8 хувь нь орон нутагт бүртгэгдэж, зам тээврийн осол хэргийн улмаас 347 хүний амь нас хохирч, 2026 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс

⁴ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2022. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Дотоод хэргийн их сургууль. УБ., 2023. 26 дахь тал

хүний амь нас хохирсон тохиолдол 5.7 хувиар буурч, гэмтсэн хүн 9.3 хувиар өссөн байна.⁵

Дээрх осол, хэргийн 615 тохиолдол нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас үйлдэгджээ.

2023 оны эхний 8 сарын байдлаар хүүхэд өртсөн зам тээврийн осол 529 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9.5 хувиар өссөн, 37 хүүхэд нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 27.5 хувиар буурсан хэдий ч гэмтсэн хүүхэд 555 бүртгэгдсэн нь 8.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Ослын улмаас нас барсан 37 хүүхдийн 21 буюу 56.7 хувь автомашинд зорчиж явсан, 13 буюу 35.1 хувь нь явганаар хөдөлгөөнд оролцсон, 3 буюу 8.1 хувь жолооч буюу мотоцикл жолоодсон бол явган зорчигч хэлбэрээр бүртгэгдсэн 13 тохиолдлын 5 буюу 38.4 хувь жолооч хөдөлгөөн эхлэх үедээ зам орчны байдлыг биеэр шалгаагүйн улмаас автомашин орчим байсан хүүхдийг дайрч амь насыг нь хохироосон байгаа бол зам тээврийн осолд өртсөн хүүхдүүдийн 246 буюу 46.5 хувь эмэгтэй, 283 буюу 53.4 хувь эрэгтэй, нийт 529 ослын 26 буюу 4.9 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийн буруутай үйлдлээс шалтгаалжээ.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, зам тээврийн ослыг сүүлийн 7 жилийн байдлаар авч үзэхэд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, зам тээврийн ослын тоо үзүүлэлтийг авч үзвэл:

№	Он	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн илрүүлэлт	Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол	Согтуу жолоочийн улмаас амь нас нь хохирсон хүний тоо
1	2017 он	30532	793	96
2	2018 он	32335	799	135
3	2019 он	34591	978	150
4	2020 он	26696	1103	112
5	2021 он	40034	1479	104
6	2022 он	54924	1210	123
7	2023.08 сар	33726	615	50
Нийт		252838	6977	770

⁵ Зам тээврийн осол, гэмт хэргийн нөхцөл байдал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийн тухай танилцуулга. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба. 2023.09.25.1 дэх тал

Дээрх тоо баримтаас харахад, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлөөс шалтгаалж, жил бүр дунджаар 110 орчим хүний амь нас хохирсон байна.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулахаар осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан нөхцөл, хор уршиг, эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулснаар хүний амь нас хохирсон тохиолдол мөн оны өмнөх үеэс 5.7 хувиар буурсан үзүүлэлттэй хэдий ч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийг илрүүлэх арга хэмжээг Улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулахад дунджаар 690 гаруй зөрчил бүртгэгдэж байгаа нь цаашид энэ төрлийн зөрчил өсөх хандлагатай байна.

Эндээс үзэхэд, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, согтуугаар зам тээврийн осол, зөрчил гаргасан жолоочид оногдуулах ял, шийтгэлийн үр нөлөө хангалтгүй, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж чадахгүй байна.

Иймд автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн хүний амь нас хохирсон, мөн хүний амь нас хохирсон гэмт хэргийг жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ үйлдсэн, энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг бүх насаар хасах нэмэгдэл ял оногдуулахаар хуулийн төсөлд тусгалаа.

ХҮЧИНДЭХ, БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ЯЛЫН БОДЛОГЫГ ЧАНГАТГАСАН ТУХАЙД:

Хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжийг өөрчилж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүчээр бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийхийг ялгамжтай байдлаар хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хуульд заасан арга хэрэглэж хүчээр бэлгийн харьцаанд орсон этгээдэд 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулж, энэ нь хөнгөн ангилалын гэмт хэрэгт хамаарч, шүүхээс хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх хууль зүйн боломжтой байсан бол хуулийн төсөлд энэхүү үйлдэлд 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар тусгасан. Ингэснээр энэхүү гэмт хэрэг нь ангилалын хувьд хүнд гэмт хэрэгт хамаарч, шүүхээс хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх боломжгүй болно.

Хохирогч хүүхдийн насны байдлаас шалтгаалж, хүчиндэх гэмт хэргийн хүндрүүлэх шинжид хуульчилж, оногдуулах ялыг ялгамжтай байдлаар нэмэгдүүлэн оногдуулахаар хуулийн төсөлд тусгасан. Тухайлбал, арван зургаан насанд хүрсэн арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн, арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн, арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол оногдуулах хорих ялын доод хэмжээ 5 жилээс дээд хэмжээ 25 жил, эсхүл бүх насаар хорих ял шийтгэхээр хуулийн төсөлд тусгасан.

Хүчиндэх гэмт хэргийн тайлбар хэсгийн агуулгыг өргөжүүлж, хүчиндэх гэмт хэргийн хохирогчоос гадна энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүн нь аль ч хүйсийн хүн

байж болохоор төсөлд тусгасан. Ингэснээр хүйсийн ялгаваргүйгээр хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хуулиар хамгаалахад томоохон алхам болсон.

Сүүлийн жилүүдэд такси үйлчилгээ үзүүлэх нэрээр охид, эмэгтэйчүүдийг хууран мэхэлж хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэх, энэ төрлийн гэмт хэрэгт бага насны охид хохирох явдал өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2018-2022 онд такси үйлчилгээ үзүүлэхээр хууран мэхэлж, хүчиндсэн 54 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна.

Иймд хүчиндэх гэмт хэргийг такси үйлчилгээ үзүүлэхээр хууран мэхэлж, мөн хохирогчийн зорчих эрхийг хязгаарлаж үйлдсэн бол хүндрүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ НУУЦЫГ ЗАДРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЯЛЫН БОДЛОГЫН ТУХАЙД:

Сүүлийн жилүүдэд мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах явдал нэмэгдэж, энэ нь хүний эрх, эрх чөлөөнд халдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг үүсгэсэн.

Иймд мөрдөн шалгах ажиллагааны талаар албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан, шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан үйлдэлд оногдуулах ялын бодлогыг чангатгаж, ялын төрлөөс торгох ялыг хасаж, хорих ялыг нэмж, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялын хэмжээг тус тус нэмэгдүүллээ. Мөн мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулсан этгээдэд нийтийн албанд ажиллах эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасах нэмэгдэл ял оногдуулахаар хуулийн төсөлд тусгасан.

Харин мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн энэхүү баримт, мэдээллийг задруулах үйлдэлд оногдуулах ялын бодлогод өөрчлөлт оруулаагүй болно.

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ СОГТУУРСАН, МАНСУУРСАН ҮЕДЭЭ ЖОООДОХ ҮЙЛДЭЛД ОНОГДУУЛАХ ХУУЛЬ ЗҮЙН ХАРИУЦЛАГЫГ ЧАНГАТГАСАН ТУХАЙД:

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 33,726 зөрчлөөс 16,168 буюу 47.9 хувийг нийслэлд, 17,558 буюу 52.1 хувийг орон нутагт тус тус илрүүлсэн байна.

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилд нийгэм болон эдийн засгийн олон хүчин зүйл нөлөөлж байгаа боловч зөрчилд хүлээлгэх хариуцлага хангалтгүй, эрх зүйн орчин боловсронгуй бус, иргэдийн архины хэрэглээ их, ухамсар дутмаг зэргээс шалтгаалан энэ төрлийн зөрчил буурахгүй байна.

Олон нийтийн цахим орчинд тавигдсан сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд, олон нийт согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, улмаар зам тээврийн гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай талаар санал бодлоо илэрхийлжээ.

Европын Холбооны ихэнх улсад согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон жолоочид 500 ба түүнээс дээш еврогоор торгох, 10 жил хүртэл хугацаагаар жолоодох эрхийг хасах, Скандинавын улсуудад орлогод суурилсан торгууль ногдуулах, хорт зуршлаас салгах зан үйлийн сургалтад хамруулах, жолоодох эрхийг 2 сараас 1 жил хүртэл хугацаагаар хасах шийтгэл ногдуулж байна. Үүнээс Холбооны Бүгд Найрамдах Герман улс тухайн зөрчлийг давтан гаргасан бол 2 оноо хасаж, 1000 еврогоор торгох, жолоодох эрхийг 3 сар хасах, 3 дахь удаагаа гаргасан бол 3 оноо хасаж, 1500 еврогоор торгох, жолоодох эрхийг 3 сар хасах захиргааны шийтгэл, Оросын Холбооны Улс тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилээс хоёр жил хүртэл хугацаагаар хасаж гучин мянган рублийн торгууль ногдуулахаар, Америкийн Нэгдсэн Улс анх удаа бол 2000 долларын торгууль оногдуулж, 180 хүртэлх хоног баривчлан, жолоодох эрхийг 1 жил хүртэлх хугацаагаар хасах, 2 дахь удаа бол 4000 долларын торгууль оногдуулж, 1 сараас 1 жил хүртэлх хугацаагаар хорьж, жолоодох эрхийг 2 жил хүртэлх хугацаагаар хасах, 3 дахь удаа бол 10000 долларын торгууль оногдуулж, 2-оос 10 хүртэлх жилээр хорьж, жолоодох эрхийг 2 жил хүртэлх хугацаагаар хасах шийтгэлийг

Манай улсад тээврийн хэрэгслийн жолооч согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг түгээмэл үйлдэхээс гадна тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох явдал ихээр бүртгэгдэж байна. Тухайлбал,

Зөрчил	2018	2019	2020	2021	2022	2023 оны эхний 9 сар
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	3522	3935	3555	5319	5227	3396
Эрхгүй хүн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	2914	3829	3460	3903	3704	3349

Эх сурвалж: Тээврийн цагдаагийн алба

Иймд Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдал, автотээврийн хэрэгслийг согтуурсан, мансуурсан үедээ жолоодох үйлдэлд хууль зүйн хариуцлага хүлээлгэж буй гадаадын зарим улсын туршлага, иргэд-олон нийтийн шаардлага, дээрх улсын хэмжээний статистик мэдээлэлд үндэслэн тээврийн хэрэгслийг

Зам тээврийн осол, гэмт хэргийн нөхцөл байдал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийн тухай танилцуулга. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба. 2023.09.25.2 дахь тал

жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн, эсхүл энэ үйлдлийн улмаас хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор төсөлд тусгалаа.

Дээр дурдсан үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэснээр зам тээврийн осол, зөрчил, түүнээс шалтгаалан хүний амь нас хохирох, эрүүл мэнд, эд хөрөнгөд учрах хохирол, хор уршгийг бууруулах, сэргийлэх, тээврийн хэрэгслийн жолооч хариуцлагажих, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс татгалзах зэрэг эерэг үр нөлөөг үзүүлнэ гэж төсөөлж байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулж байгаа бол хуулийн төсөлд энэ үйлдэлд дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тусгав.

Мөн энэ гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн дахин үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон, хүний амь нас хохирох гэмт хэргийг согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг бүх насаар хасах нэмэгдэл ял оногдуулахаар төсөлд тусгасан.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН НАСНЫ ДЭЭД ХЯЗГААРЫГ НЭМЭГДҮҮЛСЭН ТУХАЙД:

Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн тайлбарын “арван дөрвөн” гэснийг “арван зургаан” гэж өөрчилж, бага насны хүүхдийн насны дээд хязгаарыг 2 насаар нэмэгдүүлсэн. Ингэснээр Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим төрлийн гэмт хэргийн ялын бодлого чангарсан. Тухайлбал,

Одоогийн Эрүүгийн хуулиар 14 насанд хүрсэн 16 насанд хүрээгүй хүнийг алсан, эсхүл хүчиндсэн тохиолдолд 8-15 жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан

бол бага насны хүүхдийн насны дээд хязгаарыг нэмэгдүүлснээр 12-25 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар хорих ял оногдуулахаар байна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.18-д заасан иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн тул судалгаа, үнэлгээ хийх шаардлагагүй болно.

----oOo----